

**2019 ОНЫ 12 ДУГААР САРД ЭКСПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Шалгаруулалтын дугаар: СХЭИЗОСШ – 20191202

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмын дагуу 2019 оны 12 дугаар сард экспортлох стратегийн хүнс /ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН МАХ/ - ний нэр төрөл, дараах тоо хэмжээнд багтаан зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Нэр төрөл, тоо хэмжээ:

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ /тн/
1	Дулааны аргаар боловсруулсан мах	Үхрийн мах	16025000	1900
2		Хонины мах	16029000	1000
3		Ямааны мах	16029000	2100

Оролцогч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, битүүмжлэн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 11 цагаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 502 тоот өрөөнд бүртгүүлж хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Экспортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;
2. Хуулийн этгээдийн нэр, байршил, хаяг, утас, цахим хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр;
3. Татварын өргүй болохыг нотолсон харьяалах татварын албаны тодорхойлолт /2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс хойш/;
4. Аудитаар баталгаажсан сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн хуулбар;
5. Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн итгэмжлэл олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр;
6. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрийн байртай болохыг нотолсон мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт;
7. Экспортлогч улсын үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;
8. Импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн байх;
9. Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд яамтай бодлогын гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй талаар мэдэгдсэн албан бичиг;
10. Дулааны аргаар боловсруулсан мах экспортлох эрхтэй аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтад оролцох бөгөөд БНХАУ-тай байгуулсан протоколд заасны дагуу импортлогч орны хянан магадлагаанд хамрагдсан мал төхөөрөх үйлдвэрт махаа бэлтгүүлсэн тухай нотлох баримт.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 11 цаг 00 минут (Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй). Ирүүлсэн материалыг нээх хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 12 цаг 00 минут.

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-13381, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын 9 дүгээр байр, Б корпус, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 5 давхарт, 502 тоот өрөө, утас 261962